



2021 оны 06 дугаар сарын 18
№23 /1173/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠰᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠤ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠰᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠤ ᠬᠤᠷᠭᠢᠨ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ





ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

186. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баглах тухай 1643

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

187. Шүүгчийн бүрэн эрхийг сэргээх тухай Дугаар 01 1644
188. Дипломат цол олгох тухай Дугаар 99 1644

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

189. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 05 1646

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

190. “Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт” 1654



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРТ ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Үснэгт /мөм, мр /сн

Мөнхсүхэншүрэн /мр / 67000 мр, 0 - 070 - 0 мөн

Бэрлэвч /мр /
Монгол улсын засгийн газрын хөгжлийн банкны
Монгол улсын засгийн газрын хөгжлийн банкны

6 мөнхсүхэншүрэн .. Үснэгт /мөм, мр /
67000 мр, 0 - 06 - 0 мөн /мөнхсүхэншүрэн /
Монгол улсын засгийн газрын хөгжлийн банкны
Монгол улсын засгийн газрын хөгжлийн банкны ..

Үснэгт /мөм, мр /
Мөнхсүхэншүрэн /



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 01 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Шүүгчийн бүрэн эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын дээд шүүхийн шүүгч Цэндийн Амарсайханы шүүгчийн бүрэн эрхийг сэргээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 99

Улаанбаатар
хот

Дипломат цол олгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж, гадаад бодлогын тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж дараах нэр бүхий иргэдэд Дипломат цол тус тус хүртээсүгэй.

ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ЦОЛООР

1. Гончигийн Ганболд Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Элчин сайд
2. Лувсанвандангийн Болд Гадаад харилцааны сайд асан

ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН ЦОЛООР

1. Чулууны Баярмөнх Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Элчин сайд



- | | |
|-------------------------------|---|
| 2. Дашжамцын Батсайхан | Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Элчин сайд |
| 3. Дашийн Билэгдорж | Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Элчин сайд |
| 4. Ганхуурайн Баттунгалаг | Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Элчин сайд |
| 5. Зоригтын Чинтүшиг | Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Элчин сайд |
| 6. Лувсангийн Баттулга | Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Элчин сайд |
| 7. Төмөрийн Лхагвадорж | Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд |
| 8. Шагдарын Батцэцэг | Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд |
| 9. Цэрэндоржийн Нарантунгалаг | Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга |
| 10. Нэмэхийн Батаа | Гадаад харилцааны яамны Консулын газрын зөвлөх |
| 11. Мижиддоржийн Цэнгэг | Гадаад харилцааны яамны Европын газрын захирал |
| 12. Жагирын Сүхээ | Гадаад харилцааны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын зөвлөх |
| 13. Дашийн Пунцаг | Ахмад дипломатч |
| 14. Сүрэнгийн Бадрал | Ахмад дипломатч |

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2021 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.50 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр, Ш.Солонго, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Т.Сумъяабазар, түүний өмгөөлөгч Б.Пүрэвсүрэн, Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалт, Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын иргэн Т.Сумъяабазар, Л.Эрдэнэхүү нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“... Төрийн болон албаны нууцын тухай хуулийн албаны нууцад хамаарах мэдээллийн зохицуулалт болох 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.” гэж хуульчилсан байна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задрүүлж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж хуульчилж өгсөн бөгөөд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дээрх зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү зохицуулалтыг зөрчиж байна гэж үзэж байна.

Учир нь хууль тогтоох эрх мэдэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.", Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудлыг зааж өгөөд, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад "хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;" гэж заасан бөгөөд хууль батлах нь зөвхөн Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал юм. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн." гэж заасан.

Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад заасан хуулиар тогтоох ёстой асуудлыг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт зааснаар асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр баталж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт, Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчиж, өөрийн эрх хэмжээнд үл хамаарах шийдвэрийг гаргаж байна.

Ийнхүү Төрийн болон албаны нууцын тухай хуулиар албаны нууцын жагсаалтыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр баталдаг болсноос хойш 2017 онд 60 байсан нууцын мэдээлэл 2019 онд 565 болон нэмэгджээ. Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт, Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэхийг шалгаж, маргаан үүсгэн, хянан шийдвэрлэж өгнө үү." гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Үндсэн хуулийн цэцэгд ирүүлсэн тайлбартаа:

"... 1992 онд Үндсэн хууль батлагдсаны дараа нууцын хуулиудыг /Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай/ ямар үзэл баримтлалаар баталсныг авч үзэх нь зүйтэй.

Монгол Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиудад нууцыг тогтоохдоо дараах үзэл баримтлалаар хандсан байна. Төрийн нууцад хамааруулах зүйлийн хүрээ, жагсаалтыг хуульчлах, байгууллагын нууцад хамааруулах зүйлийг хуулиар тогтоох болон хуульд өөрөөр заагаагүй бол байгууллага өөрөө тогтоох, хувь хүний нууцын төрлийг хуульчлах, хувь хүн өөрөө нууцалж

болох гэжээ. Эндээс хууль тогтоогч төр, байгууллага, хувь хүний нууцыг Үндсэн хуульд заасны дагуу хуулиар тогтоосон буюу Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиудыг баталсан болохыг харж болно.

Байгууллагын нууцын тухай хуульд эрх зүйн онолын эрх шилжүүлэх зарчмыг баримтлан “байгууллага” бүр албаны онцлогтой холбоотойгоор задруулбал хууль ёсны ашиг сонирхолд хор уршиг учруулж болохуйц мэдээ, баримт бичгийг нууцад хамааруулан өөрөө тогтоож байхаар хуульчилсан байна. Байгууллага гэж тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлэх бөгөөд хуулийн этгээд бүрийн хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болохуйц мэдээ, баримт бичгийг хууль тогтоогч нэг бүрчлэн томьёолон хуульчлах боломжгүй тул эрх шилжүүлэх зарчмыг баримталсан байна. Энэ талаар Байгууллагын нууцын тухай хуулийн төслийг хэлэлцэх үеийн хууль санаачлагчийн илтгэлд “... байгууллагын нууцад чухам юу орохыг хуулиар шууд заах боломжгүй юм.” гэжээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.”, 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” гэж тус тус заасан байдаг. Олон хэвшил бүхий чөлөөт эдийн засгийн харилцаанд оролцогч байгууллага /хуулийн этгээд/ бүрт үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан “тухайн байгууллагын нууцлах зүйл”-ийг өөрөө тогтоох эрхийг олгосон бөгөөд нууцлахыг хориглох мэдээллийн хүрээг хуульчилж өгсөн байна.

Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдахаас өмнө Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу төрийн байгууллага “байгууллагын нууцаа” өөрөө тогтоодог байсан бөгөөд нууц хамгаалах журмыг мөн адил өөрөө тогтоож мөрддөг байсан. Энэ нь төрийн байгууллагын нууцыг тодорхой бус болгож, байгууллага бүр өөрийн дур зоргоор зохицуулах боломжийг олгосон. “Төрийн байгууллага” гэдэг нь бусад байгууллага, хуулийн этгээдээс онцлогтой, хуулиар хүлээсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг тул төрийн байгууллагын “байгууллагын нууц”-ыг Байгууллагын нууцын тухай хуулиар биш Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзсэн.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд төрийн байгууллагын “байгууллагын нууц”-ыг “албаны нууц” гэж нэрлэсэн бөгөөд төрийн байгууллага бүрийн албаны нууцад хамаарах мэдээллийг байгууллага бүрээр нэрлэн заах бодит боломжгүй тул 1995 онд баталсан Байгууллагын нууцын тухай хуульд хэрэглэсэн “эрх шилжүүлэх” зарчмыг баримтлан

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцын жагсаалтыг баримтлахаар хуульчилсан. Энэ эрхийг байгууллагын удирдлага дур зоргоор эдлэхээс сэргийлэн албаны нууцыг тогтооход баримтлах шалгуур, зэрэглэл, хугацаа, ил болгох журам зэргийг хамт хуульчилсан.

Тухайлбал, албаны нууц гэдгийг тодорхойлсон; албаны нууцын зэрэглэл, шалгуурыг хуульчилсан; нууцлах хугацааг тодорхой заасан; нууцлах журмыг хуульчилж, албаны нууцад хамаарахгүй мэдээлэлд “нууц” тэмдэглэгээ хийхийг хориглосон; ил болгох журмыг хуульчилсан; албаны нууцын жагсаалтыг батлахад тагнуулын байгууллагын саналыг авах зэрэг. Төрийн байгууллага өөрийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “албаны нууцын жагсаалт”-ыг батлахдаа Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль зэрэг төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, иргэний мэдээлэл авах эрхийг хангахтай холбоотой хуулийн шаардлагыг тус тус дагаж мөрдөнө.

Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэснийг зөрчөөгүй болно.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1. ... Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.3.2-т “Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг боловсронгуй болгоно.” гэж заасны зэрэгцээ төрийн нууцад хамаарах мэдээллээс гадна төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэхэд тодорхой хугацаанд, зохих хэмжээнд нууцалбал зохих мэдээлэл орхигдох, эсхүл төрийн нууцтай холбоотой албан хэрэг хөтлөх явцад нууцлах шаардлагатай боловч төрийн нууцад хамааруулах боломжгүй бүртгэл, тайлан, илтгэл, мэдээлэл, акт үйлдэх болон нууц мэдээлэл тээгчтэй холбоотой мэдээллийг албаны нууцад хамааруулан хамгаалах эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байсан болно.

Төрийн болон албаны нууцын тухай хууль хэрэгжихээс өмнө төрийн байгууллагын албаны нууцтай холбогдох харилцааг Төрийн нууцын тухай хууль /хүчингүй болсон/-аар бус Байгууллагын нууцын тухай хуулиар зохицуулж байсан бөгөөд уг хуульд төрийн байгууллагын албаны нууцыг хуулийн этгээдийн нууцаас ялгаж, нарийвчлан тусгаагүй, албаны нууцад хамаарах мэдээллийг тогтоох үндэслэл, журмын талаар тодорхой зохицуулалтгүйн улмаас албаны нууцыг байгууллага тус бүр харилцан адилгүй тогтоож ирсэн байна. Энэ нь албаны нууц, түүнд хамаарах мэдээллийн хамгаалалтыг сулруулах, нэгдсэн удирдлага, хамгаалалт, хяналтгүй болох хүчин зүйл болж байсан.

Иймд хууль тогтоогчийн зүгээс нууц мэдээлэлд “албаны нууц” гэх ангиллыг шинээр бий болгон тодорхой шаардлага, шалгуур хангасан мэдээллийг албаны нууцад хамааруулах, албаны нууцын мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батлахаар Төрийн болон албаны нууцын тухай хуульд тусгаж, хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж заасан нь мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг хязгаарлаагүй бөгөөд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах “албаны нууц”-ыг хуулиар тогтоож, хэрэглэхийг хориглосон хэм хэмжээ биш юм.

2.Төрийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээлэл нь төрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон, нууцалбал зохих мэдээлэл байдаг бөгөөд задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах үр дагавартай байдаг.

Иймд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах, төрийн нууцад хамаарах болон албаны нууцад хамаарах мэдээллийг тэр бүр хуулиар тогтоох, нэмэлт, өөрчлөлт оруулах боломж хязгаарлагдмал тул хууль тогтоогчийн зүгээс Үндсэн хуулиар олгогдсон “хууль тогтоох” бүрэн эрхээ Төрийн болон албаны нууцын тухай хуулиар шилжүүлсэн байна.

Тухайлбал, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ хуулийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна.” гэж, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны

нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.” гэж тус тус хуульчилсан.

Олон улсын эрх зүйн түгээмэл хандлага, суурь зарчмаар нэгэнт тогтсон “delegation of power” буюу төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу зарим бүрэн эрхээ хууль, гэрээний үндсэн дээр шилжүүлэх боломжтой байдаг. Энэ суурь зарчим, ойлголт манай хууль тогтоомжуудад мөн тусгалаа олсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна.” гэж, 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан зарим органик хуулиар Засгийн газар болон бусад байгууллагуудад хууль тогтоох бүрэн эрхийг шилжүүлж байна.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Засгийн газар хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний акт гаргаж болох бөгөөд тогтоол хэлбэртэй байна.” гэж зааснаас үзвэл Улсын Их Хурал нь Засгийн газарт хууль тогтоох эрхийг шилжүүлэх боломжийг ийнхүү хуульчилсан байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулиар Засгийн газар тогтоохоор тусгайлан эрх олгож, заасны дагуу Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоол, мөн өдрийн 247 дугаар тогтоолоор төрийн болон албаны нууцтай холбогдох журам, жагсаалтыг тус тус батлан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

3. Улсын Их Хурлаас баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд “албаны нууц” гэсэн ойлголтыг тодорхойлж, нууцад хамааруулах мэдээллийн шалгуурыг тогтоож, мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан бол ил тод болгох зохицуулалт, шалгуурын дагуу нууцалбал зохих мэдээллийг нууцлаагүйгээс үүдэх эрх зүйн үр дагаврыг нарийвчлан тусгаж, зохицуулсан болно.

Тухайлбал, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад ““албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;” гэж, 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэгт “Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол, үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг “нууц”

зэрэглэлд хамааруулна.” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрийн болон албаны нууцыг дараахь үндэслэлээр ил болгоно.” гээд 19.1.4 дэх заалтад “мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон.” гэж тус тус хуульчилсан.

Түүнчлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 39 дүгээр зүйлд уг хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой хуульчилснаас үзвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. ...” гэж заасан нь Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх эрхийг баталгаажуулсан байна.” гэжээ.

Дөрөв. Мэдээлэл гаргагч, иргэн Т.Сумъяабазар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээллийн шаардлагаа ихэсгэсэн болно. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.” гэж зохицуулсан. Энэ нь төрийн нууцтай холбоотой асуудлыг зөвхөн хуулиар тогтоож байх Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон шаардлагыг алдагдуулж, албаны нууцад хамаарах мэдээллийг хуулиар бус, харин гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болох Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр баталж байна. Ийнхүү төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох хууль дээдлэх зарчим зөрчигдөж, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэрт байдлыг алдагдуулан, хуулийн биелэлтийг хангах учиртай Засгийн газар, Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэр, үзэмжээр Үндсэн хуулиар олгогдоогүй эрх хэмжээ, бүрэн эрхийг эдэлж, хэрэгжүүлэхэд хүргэсэн байна.

Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасны “... хууль дээдлэх ...” гэснийг, Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж заасны “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэснийг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж заасны “... хууль батлах ...” гэснийг тус тус зөрчиж буй тул хянан хэлэлцэж, дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1.“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж заасны дагуу Улсын Их Хурлаас 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Хувь хүний нууцын тухай хууль, 1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Байгууллагын нууцын тухай хууль, 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Төрийн болон албаны нууцын тухай хуулийг тус тус баталсан байна.

2.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.” гэж хуульчилжээ. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн уг зохицуулалтаас үзэхэд үндсэн хуулийн эрх зүйн онолын суурь зарчмын дагуу Улсын Их Хурал хуулийн хүрээнд холбогдох бүрэн эрх, чиг үүргээ шилжүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч Үндсэн хуулийн дагуу төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тодорхойлж, хэрхэн хамгаалахыг тогтоосон байна.

3.Монгол Улсын Үндсэн хуульд заасан мэдээлэл хайх, хүлээн авах иргэний үндсэн эрхийг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд нууцалж үл болох албаны мэдээллийн хүрээ хязгаарыг тогтоох, нууцалсан шийдвэрт гомдол гаргах үндэслэл, журмыг нарийвчлан хуульчлах шаардлагатай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

4.Мэдээлэл гаргагч иргэн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээллийн шаардлагаа ихэсгэсэн байна. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 09 дүгээр магадлалд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх асуудал нь үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй гэж үзэн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй байна. Иймд уг ихэсгэсэн шаардлагын хүрээнд Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

**Б.БУЯНДЭЛГЭР
Ш.СОЛОНГО
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН**

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС

БОЛОН

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)

ХООРОНДЫН

**ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ САНХҮҮЖИЛТИЙН
ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРТ ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

2020-2021 ОНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮҮНЭЭС:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор Монгол Улс, АХБ Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (“Шуурхай хариу

арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”)-ийг 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын Улаанбаатар хотноо байгуулсан. Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлаар 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр соёрхон батлагдаж, хууль болсон.

2. КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх ноцтой хүндрэл эсхүл нийгэм, эдийн засагт үзүүлэх хүндрэлийг даван туулах арга хэмжээг 2021 онд үргэлжлүүлэн, тасралтгүй авч хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улс хүсэлт гаргаж, АХБ зөвшөөрсний үндсэн дээр Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тохиров. Үүнд.

- (a) Нэгдүгээр зүйлийн Хэсэг 1.02-ыг дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

“(a) 2020 онд зуун тавин зургаан сая дөрвөн зуун мянган ам.доллар (156,400,000 ам.доллар) -ын зээлийн эх үүсвэрийг АХБ-ны энгийн болон хөнгөлөлттэй энгийн эх үүсвэрийн сангаас санхүүжүүлсэн;

(b) 2021 онд гурван зуун арван гурван сая зургаан зуун мянган ам.доллар (313,600,000 ам.доллар)¹-оос хэтрэхгүй зээлийн эх үүсвэрийг АХБ-ны энгийн болон хөнгөлөлттэй энгийн эх үүсвэрийн сангаас санхүүжүүлж болно

(c) Монгол Улс энэхүү зээлийн эх үүсвэр нь амлалт гэдгийг хүлээн зөвшөөрч байна. АХБ-ны зүгээс Монгол Улсад олгох зээлийн бодит хэмжээг зохих журмын дагуу баталгаажуулна.”

- (b) Нэгдүгээр зүйлийн Хэсэг 1.03-ыг дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

“Хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төсөл(үүд)-ийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, материал, барилгын ажил дээр ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөх хэлбэрээр санхүүжилт гаргана.”

¹ 2021 онд АХБ-наас олгох нэг зуун далан сая ам.долларын (170,000,000 доллар) нэмэлт зээлийн эх үүсвэрийг Монгол Улсаас санал болгож байгаа (i) КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх хөгжлийн төсөл (үүд); болон (ii) КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад Монгол Улсад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр(үүд)-ийг санхүүжүүлэхэд ашиглана.



3. Дээр дурдсан заалтуудаас бусад тохиолдолд Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр хэвээр үлдэнэ.
4. Энэхүү Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын Их Хурал соёрхон баталсан өдрөөр хүчин төгөлдөр болж, Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөртэй ижил хугацаанд хүчин төгөлдөр байна.
5. Энэхүү Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт нь Шуурхай хариу арга хэмжээ аван санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн салшгүй хэсэг байх ба Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөртэй ижил хууль зүйн хүчин чадалтай байна.

--Заалтуудын төгсгөл--

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.

Хөтөлбөрийг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ төлөөлж

АЗИЙН ХӨГЖЛИЙН
БАНКЫГ төлөөлж

БОЛДЫН ЖАВХЛАН
Сайд
Сангийн яам

ПАВИТ РАМАЧАНДРАН
Монгол Улсыг хариуцсан
захирал
Суурин төлөөлөгчийн газар

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeleel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 200003